



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 701

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын  
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Увс аймгийн Шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 18,400,000.00 (арван найман сая дөрвөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Увс аймгийн Шүүхийн тамгын газрын дарга Л.Баттулгад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн  
701 дугаар тогтоолын хавсралт

**Шүүхийн ерөнхий зөвлөлийн харьяа Увс аймгийн Шүүхийн тамгын газрын хөрөнгөд  
бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин**

Д/д	Автомашины нэр, зориулалт, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	УАЗ-31512 маркийн суудлын автомашин, улсын дугаар УВА 51- 25, арлын дугаар 315100В00586543	2011/2011	46260	18,400,000.00	1,000,000.00
<b>Нийт дүн</b>				<b>18,400,000.00</b> <b>(арван найман сая дөрвөн зуун мянга)</b>	<b>1,000,000.00</b> <b>(Нэг сая)</b>